

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 18/03/05

Улаанбаатар хот

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлүүд 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож амжаагүй эсвэл хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компаний тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
2. Хувьцаагаа эргүүлэн Компанид зарах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хувьцаа эргүүлэн авах журмыг боловсруулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан ажиллахыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөл энэхүү ажиллагаанд хяналт тавьж ажилласугай.

ХУРЛЫН ДАРГА*Г.Гомбо***Г.ГОМБО**

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар:18/03/04

Улаанбаатар хот

ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ
ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.12 заалт, 38-р зүйл, 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхээр шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГОМБО

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 18/03/03

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2018 оны 4-р сарын 30 –ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 18/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хувьцааны төвлөрлийг сааруулах зорилгоор 50 000 000 ширхэг хүртлэх энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрсөн тул компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50 000 000 ширхэг хүртлэх энгийн хувьцаатай байна гэж компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлсүгэй.
3. Компанийн дүрэмд оруулж буй хувьцааны тооны нэмэлт өөрчлөлт нь Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрсөн тоо ширхэгийн хүрээнд байхыг анхааруулсугай.
4. Компанийн хувьцааг бүртгүүлэх, компанийн дүрмийг бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай.
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА**Г.ГОМБО**

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 18/03/06

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 18/02/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

Ердийн гишүүн

1. Г.Оюунболд
 2. Г.Алтаймаа
 3. Камолидин Талипов
 4. Б.Отгонтуяа
 5. О.Амартүвшин
 6. Г.Санжаасүрэн
2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

Хараат бус гишүүн

1. Ц.Нэргүй
2. Х.Батзаяа
3. Б.Хосбаяр

3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГОМБО

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 18/03/02

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн дугаар зүйл, 32-р зүйлийн 32.5, 42-р зүйлийн 42.4 дэх заалтууд, 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 18/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Люкс Занаду Групп” ХК компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх, хувьцааныхаа төвлөрлийг сааруулах зорилгоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50 000 000 ширхэг хүртлэх энгийн хувьцаа нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай.
3. 50 000 000 ширхэг хүртлэх энгийн хувьцааг нэмж гаргах шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГОМБО

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар: 18/03/01

Улаанбаатар хот

ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2018 оны 4 сарын 30-ны өдрийн тооллогын комиссын 18/02/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн танилцуулсан дүгнэлтийг баталсугай.
2. 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн компанийн бизнес төлөвлөгөө, үнэт цаасны төслүүдийг нэмэлт оруулан сайжруулан дахин батлахыг ТУЗ-д үүрэг болгосугай.
3. Баталсан төсөл, төлөвлөгөөнүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн үр бүтээлтэй ажиллахыг компанийн Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГОМБО